Хотын стандарт хяналтын газар

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт
## / 2023 оны IY сарын тайлан мэдээ /

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | 2023 оны IY сарын хэрэгжилтийн **үр дүнгийн тухай** мэдээлэл | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | | 30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан | | | Хэрэгжилтийн явц | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | ХБ | Санхүүжилтээс | Зохион байгуулалтаас | Урт хугацаанд хэрэгжих | Бүрэн хэрэгжсэн | Тодорхой ахиц гарсан | Ажил огт хийгдээгүй |
| | | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | | | | |
| 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.5. . Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар иргэдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартыг хэрэгжилтийг 4 бүлгийн 126 арга хэмжээг бүхий нэгдсэн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж байна. Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг дүүрэг бүрд хариуцан хэрэгжүүлэх ажлын хэсгүүдийг дүүргүүдийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Ажлын хэсгүүдэд тус газрыг төлөөлж ажиллах нийт 29 албан хаагчийг газрын даргын 2023 оны А/20 дугаар тушаалаар томилсон. Эдгээр албан хаагчид нь норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх, сургалт арга зүйгээр хангах, тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явцад зөвлөн туслах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу | | | + | | | | | + | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав; | гүйцэтгэж байна. Тухайлбал:<br>- UCS0901B:2022 “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага”, UCS0903A:2022 “Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын шаардлагыг авто зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичиг, ажлын даалгаварт тусгаж хэрэгжилтэд хяналт тавих талаар Нийслэлийн Замын хөгжлийн газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/357 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Хотын стандартын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, арга зүйгээр хангах, чиглүүлэх сургалтыг 2023 оны 4 дүгээр сард нийслэлийн **7** дүүрэгт зохион байгуулан **600** гаруй албан хаагчдыг хамруулав.<br>- Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/394 дүгээр захирамжийн дагуу газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайг нэмэгдүүлэх зорилгоор Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нийт **46** байршилд UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалт хийж эхлээд байна. | | | | | | | | | | | |
| | XX.5.2. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, | Шинэчлэн батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын нийслэл | + | | | | | | | | + | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нормативын баримт бичиг, стандартаар тогтоосон шаардлагыг хангуулах асуудлыг хуульчлах боломжтой эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан судалж, танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав. | Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулинд нийслэл хот стандарттай байх бөгөөд түүнийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас баталж нийтээр дагаж мөрдөхөөр зохицуулсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх 9 бүлгийн 38 хотын стандартыг баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж эхэлсэн. Дээрх 9 бүлгийн 38 хотын стандартад ногоон байгууламжтай холбоотой -5, явган зам, дугуйн замтай холбоотой-2 хотын стандарт тус тус батлагдсан.<br><br>Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамж, 2023 оны А/242 дугээр захирамжаар стандарт, нормын мөрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2023 оны хувьд нийт 126 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөөнд тохижилт, бүтээн байгуулалтын ажилд ногоон байгууламж, явган зам, дугуйн замын стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх хүрээнд зөвлөн туслах, хяналт тавих чиглэлийн нийт 18 арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Иймд ногоон байгууламж, явган ба дугуйн замын стандарт, нормыг мөрдүүлэх асуудлыг хуульчлах асуудал бүрэн хэрэгжсэн гэж үзэж болно. | | | | | | | | | | | |
| 2022 оны 9 | IX.1.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/323 дугаар | | | + | | | | | + | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах, сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | захирамжаар газар ашиглалтыг сайжруулах, явган зам, талбайн хүрэлцээг нэмэгдүүлэх, зөвшөөрөлгүйгээр хашаа, хайс барьсан зөрчлийг арилгах, чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Ажлын хэсэг хуралдаж нийт 111 байршлын 8771 метр урт хашааг буулгаж, 46 байршлын 7486 метр урт хашаанд UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” хотын стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/394 дүгээр захирамж гарч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | | | | | | | | | | | |

---oOo---

Хотын стандарт хяналтын газар

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт
## / 2023 оны Y сарын тайлан мэдээ /

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | 2023 оны Y сарын хэрэгжилтийн **үр дүнгийн тухай** мэдээлэл | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | | 30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан | | | Хэрэгжилтийн явц | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 30 | 0 | ХБ | Санхүүжилтээс | Зохион байгуулалтаас | Урт хугацаанд хэрэгжих | Бүрэн хэрэгжсэн | Тодорхой ахиц гарсан | Ажил огт хийгдээгүй |
| | | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | | | | | |
| 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.5..Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгүй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн дагуу иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм дүрэм, стандартыг хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 126 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэ хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд ногоон байгууламж, явган зам, дугуйн замын стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх хүрээнд зөвлөн туслах, хяналт тавих ажлыг эхлүүлээд байна.<br>Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, сурталчлан таниулах ажлын хүрээнд 2023 оны 5 дугаар сард нийслэлийн 8 дүүргийн нийт 580 гаруй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад | | + | | | | | | | | + | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав; | хотын стандартын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, арга зүйгээр хангах, чиглүүлэх сургалтыг зохион байгуулж ажилласан. | | | | | | | | | | | |
| | XX.5.2. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартаар тогтоосон шаардлагыг хангуулах асуудлыг хуульчлах боломжтой эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан судалж, танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав. | Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулинд нийслэл хот стандарттай байх бөгөөд түүнийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас баталж нийтээр дагаж мөрдөхөөр зохицуулсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх 9 бүлгийн 38 хотын стандартыг баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж эхэлсэн. Дээрх 9 бүлгийн 38 хотын стандартад ногоон байгууламжтай холбоотой -5, явган зам, дугуйн замтай холбоотой-2 хотын стандарт тус тус батлагдсан.<br>Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамж, 2023 оны А/242 дугээр захирамжаар стандарт, нормын мөрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2023 оны хувьд нийт 126 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөөнд тохижилт, бүтээн байгуулалтын ажилд ногоон байгууламж, явган зам, дугуйн замын стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх хүрээнд зөвлөн туслах, хяналт тавих чиглэлийн нийт 18 арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Иймд ногоон байгууламж, явган ба дугуйн замын стандарт, нормыг мөрдүүлэх асуудлыг хуульчлах асуудал бүрэн хэрэгжсэн гэж үзэж болно.<br>Мөн Барилга, хот байгуулалтын яамнаас Хот, | + | | | | | | | | + | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суурины ногоон байгууламжийн тухай анхдагч хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төсөл, холбогдох судалгааны хамт боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөлд чиг үүргийн хүрээнд холбогдох саналыг тусган, тандан судалгааны тайлангийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. | | | | | | | | | | | |
| 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах, сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/394 дүгээр захирамжийн дагуу газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайг нэмэгдүүлэх зорилгоор Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт нийт 46 байршилд UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” хотын стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалт хийх үүрэг өгөгдсөн. Дээрх ажлын дагуу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд байгуулагдсан стандарт, норм дүрмийг хангуулах дээрх 3 дүүргүүдийн дэд ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгуулан стандарт мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна. | | + | | | | | | | | + | |

---oOo---

Хотын стандарт, хяналтын газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт
/ 2023 оны эхний хагас жилийн тайлан мэдээ /

2023 оны 06 дугаар сарын 30 Улаанбаатар хот

| | | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилт | Хэрэгжилтийн үнэлгээ | Үр нөлөө | Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ | Хүчингүй болсон буюу хяналтаас хасуулах тухай тэмдэглэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | УИХ-ын тогтоол | | | | | |
| | 1. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62 | 1.3/а/. 3/Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар: а/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах; | 2023 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан А/89, А/296 тушаал, захирамжаар “Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байна. Энэхүү журмын төслийг боловсруулахад холбогдох стандартуудын талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн. Цаашид журмын төслийг эцэслэн боловсруулж холбогдох нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахад чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.<br>Мөн тус газраас чиг үүргийн хүрээнд орчны бохирдол, байгалийн тэнцэл | 70% | Хөрсний бохирдлыг бууруулах бүсчлэлийг тогтоож, мөрдөх дэглэмийг тодорхой болгосноор үе шаттайгаар хотын хөрсний чанар сайжрах нөхцөл бүрдэнэ. | Ажлын хэсгийн хуралдаанд оролцож санал өгөх, чиг үүргийн хүрээнд дэмжин ажиллах, байгаль орчны чиглэлээр батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан таниулах. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | алдагдахаас сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:<br>- “Барилгын хог хаягдлын менежмент” хотын стандартын зөвлөмж 144 барилгад, “Аюултай хог хаягдлын менежмент”-н зөвлөмжийг 21, “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандартын зөвлөмж 70 аж ахуйн нэгжид хүргүүлсэн,<br>- Хотын стандартын сургалтыг нийт 11 удаа 1300 орчим иргэн ААНБ-г хамруулан “Хог хаягдлын менежмент”, “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” сэдвээр зохион байгуулаад байна. | | | | |
| | 2. | | 1.3/в/. Улаанбаатар хотын агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх; | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа нүхэн жорлонгийн тоог бууруулж бохирдсон хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээг оновчтой тусгах зорилготой. | 70% | Нийслэлийн хэмжээнд хөрс хамгаалж цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, нүхэн жорлонгийн тоог бууруулна | Төлөвлөгөөний төсөлд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг тусгуулан чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана. | - |
| | | | ЗГ-ын тогтоол | | | | | |
| | 3. | Хяналт шалгалтын | 3. Хяналт шалгалтын үйл | Байгууллагын чиг үүргийн дагуу хяналт | 90% | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө батлах тухай<br>2023-01-11<br>Дугаар 2023_79 | ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийн санхүүжүүлж байна. | | | | |
| | | | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| | 4. | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл<br>2022-05-11<br>Дугаар 2022_28 | XX.5.1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав; | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага UCS0901B:2022, Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага UCS0903A:2022 хотын стандартуудыг авто зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичиг, ажлын даалгаварт дээрх стандартуудыг тусгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай албан бичгийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Замын хөгжлийн газар, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. | 50% | Явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажил сайжирна. | 3 дугаар улиралд Улс нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа явган зам, дугуйн замын угсралтын ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5. | | XX.5.2. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартаар тогтоосон шаардлагыг хангуулах асуудлыг хуульчлах боломжтой эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан судалж, танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт даалгав. | Шинэчлэн батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл хот стандарттай байх бөгөөд түүнийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас баталж нийтээр дагаж мөрдөхөөр зохицуулсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх 9 бүлгийн 38 хотын стандартыг баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж эхэлсэн. Дээрх 9 бүлгийн 38 хотын стандартад ногоон байгууламжтай холбоотой -5, явган зам, дугуйн замтай холбоотой-2 хотын стандарт тус тус батлагдсан.<br><br>Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулж Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамж, 2023 оны А/242 дүгээр захирамжаар стандарт, нормын мөрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2023 оны хувьд нийт 126 арга хэмжээ бүхий нэгдсэн төлөвлөгөөнд тохижилт, бүтээн байгуулалтын ажилд ногоон байгууламж, явган зам, дугуйн замын стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх | 100 | - | - | Тийм |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүрээнд зөвлөн туслах, хяналт тавих чиглэлийн нийт 18 арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Иймд ногоон байгууламж, явган ба дугуйн замын стандарт, нормыг мөрдүүлэх асуудлыг хуульчлах асуудал бүрэн хэрэгжсэн гэж үзэж болно. | | | | |
| | 6. | 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.14. Нийслэл Улаанбаатар хотод оршин суух, явганаар болон дугуйгаар зорчих эрүүл, аюулгүй орчин, боломжийг бүрдүүлэх, хайс, хашааг буулгаж явган замын тасралтгүй байдлыг хангах, сүлжээг одоогийн байгаагаас хоёр дахин нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/394 дүгээр захирамжийн хүрээнд Баянгол дүүргийн 38, Баянзүрх дүүргийн 4, Сүхбаатар дүүргийн 4, нийт 46 байршилд UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага” хотын стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг өгөгдсөн. Энэ дагуу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд дүүргүүдэд байгуулагдсан дэд ажлын хэсгүүдтэй хамтран ажиллаж дээрх байршлуудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан стандартын дагуу шинэчлэх талаар улсын (ахлах) байцаагчийн зөвлөмж, мэдэгдлийг холбогдох иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн эзэн холбогдогч нь тодорхойгүй байршлуудад мэдэгдэх хуудас хүргүүлэв. | 70 | Газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хашаа, хайсын өнгө үзэмжийг сайжруулах, стандартын дагуу шинэчлэх | - |

---oOo---